4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нэрт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

РСОДХҮҮ

006633



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 06

Дугаар А/838

Үүснэ-болгогч хэсэг

Эрхийн улсын бүртгэлийн Y-2204030453
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн З.Норовсүрэн /У357060111/, Д.Сүрэн /ЛЕ60041801/, Н.Байгалмаа /ЛЕ83031409/, Н.Сугармаа /ШУ89021729/, Н.Азбаяр /ЛС94072218/, Б.Мөнх-Од /УВ03310719/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204030453 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо Усан сангийн 1 дүгээр гудамжны 8 тоот хувийн сууцны зориулалттай барилга нь гал гарч шатаж устсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204030453 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, улсын бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204030453 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000108591 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2204030453 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийг хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч С.Одгэрэлд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/839

Улаанбаатар хот

Томилолтоор ажиллуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюуны өмчийн ерөнхий ойлголт, Патентийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийг сурталчилах зорилгоор Хяналтын газрын хяналтын улсын байцаагч С.Ганзоригийг 2017 оны 9 сарын 29-ны өдөр Төв аймагт томилолтоор ажиллуусугай.

2. Томилолтын болон шатахууны зардал 80275 /наян мянга хоёр зуун далан тав/ төгрөгийг байгууллагын холбогдох зардлаас гаргахыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Ч.Хүрэлбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

БАТЛАВ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА Р.СОДХҮҮ

СУРГАЛТЫН УДИРДАМЖ

2017.09.29

Улаанбаатар хот

Сургалтын зорилго, үндэслэл:

- "Патентийн тухай хууль", "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хууль, "Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль", Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенцийн сурталчлах "Оюуны өмчийн ерөнхий ойлголт"-ыг сэдвийн хүрээнд багцлан ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад анхан шатны мэдлэг, мэдээлэл өгөх;

Сургалтын бүрэлдэхүүн:

- Хяналтын улсын байцаагч С.Ганзориг, жолооч У.Баярсайхан

Төв аймгийн Зуунмод сумын ерөнхий боловсролын сурагч нарт

Сургалтын хугацаа:

- 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр болно.

Сургалтыг тайлагнах:

- Сургалт дууссанаас хойш ажлын 5 хоногт багтааж тайлагнана.

Оюуны эмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2017 оны 1139 дугаар тушаалын хавсралт

АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН
ТӨСӨВ

№	Зардлын нэр	Ажиллахалбан хаагчийн тоо	Нэг хоногийн зардал /төгрөгөөр/	Нийт зардлын дүн /төгрөгөөр/
1	Томилолтын зардал /1 хоног/ Төв	2	29.000	58000
4	Замын зардал /Төв аймаг/	90км x 0.15 x 1600		22275
НИЙТ ДҮН				80275



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/840

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1. Иргэн Г.Баярмаа /АЭ70082503/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0106000061 дугаарт бүртгэлтэй, Архангай аймгийн Эрдэнэмандал сум, Өлзийт баг, Өлзийт хороолол, 8 дугаар гудамжны 02 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000112528 дугаартай;

1.2. иргэн Ц.Уранчимэг /МБ69032502/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Ү-0416000231 дугаарт бүртгэлтэй, Булган аймгийн Рашаант сум, 2 дугаар баг, Замын үйлчилгээний төвд байрлах Цагаан хайрхан зоогийн газрын 144729 дугаартай;

1.3. иргэн Б.Сүрэн /РЭ54070368/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-1723001998 дугаарт бүртгэлтэй, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 11 дүгээр баг, 11 дүгээр гудамжны 20 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000083943 дугаартай;

1.4. иргэн Г.Үүрийнтуяа /ЖЮ03242161/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614017173 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 10 дугаар баг, Дэлгэрэх 5 дугаар гудамжны 07 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000328265 дугаартай;

1.5. иргэн Х.Туваансүрэн /ЖМ87032798/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614003392 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 1 дүгээр баг, Силикатын зүүн талд байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000128319 дугаартай;

1.6. иргэн Х.Туваансүрэн /ЖМ87032798/, Ж.Батцэцэг /ЖМ88052661/, Т.Хаянхярваа /ЖМ08292811/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Ү-0614006491 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 1 дүгээр баг, Силикатын зүүн талд байрлах хувийн сууцны 000148220 дугаартай;

1.7. иргэн Р.Оюун /ЖЭ58061700/, Ц.Рэнцэндорж /ЖЮ31100675/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614002324 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 3 дугаар баг, Бат-Уул 3-26 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 42098 дугаартай;

007065

1.8. иргэн Э.Анхбаяр /ЖЭ89102376/, С.Бадамханд /ЖЭ67092768/, Э.Баярмаа /ЖЯ92081704/, Э.Отгонбаяр /ЖЯ94091212/, Д.Энхболд /ЖЯ66010418/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614007787 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 10 дугаар баг, Хивс 5-25 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000190291 дугаартай;

1.9. иргэн Д.Түмэн-Өлзий /ЖЭ63122612/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0614007108 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 3 дугаар баг, Овоот 52-07 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 244930 дугаартай;

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болсонд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

РСОДХҮҮ

The image shows a rectangular stamp area with a grid pattern. Overlaid on the stamp is a large, handwritten signature in black ink. To the left of the signature, the word 'ДАРГА' is printed. To the right, the word 'РСОДХҮҮ' is printed. The signature is written in a cursive style and extends across the stamp and slightly beyond its boundaries.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/841

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206030613,
Y-2206030032 дугаарыг хүчингүй болгож,
Y-2206029928 дугаартай бүртгэлд
нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Г.Тэнгэр /ЧЛ74032572/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206030613, Y-2206030032 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Маршал Таун хотхон Олимп гудамж 118 байр 128/б, 128/в тоот орон сууцыг өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206029928 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Маршал Таун хотхон Олимп гудамж 118 байр 128/а тоот орон сууцтай нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2206030613, Y-2206030032 дугаарыг тус тус хүчингүй болгож, Y-2206029928 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2206030613, Y-2206030032, Y-2206029928 дугаартай бүртгэлийг нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000576282, 000601143, 000296449 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2206030613, Y-2206030032 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Y-2206029928 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ж.Уранцэцэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

002911



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/842

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011897
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэргийг
хааж, эрхийн улсын бүртгэлийн
Г-2206007314 дугаартай бүртгэлд
нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н.Чулуунхүү /ШЕ71052516/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2206011897 дугаартай Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Буянт-Ухаа 13 дугаар гудамжны 488а тоот гэр бүлийн хэрэгцээний газрыг эрхийн улсын бүртгэлийн Г-2206007314 дугаартай Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Буянт-Ухаа 13 дугаар гудамжны 488 тоот гэр бүлийн хэрэгцээний газартай нэгтгэсэн тул эрхийн улсын бүртгэлийн Г-2206011897 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж, эрхийн улсын бүртгэлийн Г-2206007314 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011897 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж, эрхийн улсын бүртгэлийн Г-2206007314 дугаарт нэгтгэж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000368776, 000368778 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2206011897 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, эрхийн улсын бүртгэлийн Г-2206007314 дугаартай бүртгэлд нэгтгэж, өмчлөх эрхийн гэрчилгээ шинээр олгохыг Хан-Уул дүүргийн Улсын Бүртгэлийн Хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Д.Лхагвахандад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушвалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын Бүртгэлийн Хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА _____ Р.СОДХҮҮ

002903



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар N/893

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206008064
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн М.Содномцэрэн /ШЕ71041864/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206008064 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 5 дугаар хороо, Яармаг 4 гудамж, 104 тоот хувийн сууцыг нурааж, шинээр байшин барьсан тул эрхийн улсын бүртгэлийн Y-2206008064 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2206008064 дугаарын бүртгэлийг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000434886 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Хувийн хэрэг бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Ж.Уранцэцэгт зөвшөөрсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



002907



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10

Дугаар А/87М

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-0605000046
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ү.Бөхчулуун /ЖЕ76061378/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0605000046 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Дашбалбар сум, Улз 5 дугаар багт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрх Дорнод аймгийн Засаг даргын 2017 оны А/87 тоот захирамжаар дуусгавар болсон байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-0605000046 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-0605000046 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000357281 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-0605000046 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Ууганчимэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007067



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Тугаа А/845

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1723005123
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн О.Батцогт /РП71062035/, Г.Болортуяа /РП72010904/, Б.Сарангоо /РП98031704/, Б.Эрхсаран /РП09211502/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-1723005123 дугаарт бүртгэлтэй, Хөвсгөл аймгийн Мөрөн сум, 3 дугаар баг, 7 дугаар гудамжны 25 тоот хаягт байрлах хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-1723005123 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1723005123 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000119771 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1723005123 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Мягмарсүрэнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Хөвсгөл аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Очирхуяг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007071



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/846

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2201039687
дугаарыг хүчингүй болгож хувийн
хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Х.Ганбаатар /ЧН65021513/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2201039687 дугаарт бүртгэлтэй. Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хороо, Агарын 4 дүгээр гудамжны 10 тоот хаягт байрлах, хувийн сууцаа буулгаж, нураасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2201039687 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201039687 дугаарыг хүчингүй болгож хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000365541 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2201039687 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Д.Солонготуяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Г.Цолмон нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

004493



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/847

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2206010426
дугаарыг хүчингүй болгож,
хувийн хэрэг бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь


1. Иргэн Г.Мягмаррагчаа /ЗИ85073013/, Д.Ганболд /ЗИ60051415/, Б.Долгор /ЗИ62093006/, Г.Дүгэррагчаа /ЗИ84011417/, Г.Бадамрагчаа /ЗИ87041506/, Г.Дуламрагчаа /ЗИ82062102/, Г.Тэнгис /УП00210355/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2206010426 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Арцат 7 дугаар гудамжны 319 тоот хувийн сууц нь түймэр гарсны улмаас шатсан тул эрхийн улсын бүртгэлийн Y-2206010426 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Дугаар бүхий эрхийн улсын бүртгэлийн Y-2206010426 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000062523 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Хувийн хэрэг бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Н.Батсүхэд завшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн

Тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч С.Мөнхзаяа нарт тус тус үүрэг болгосугай.





ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 10

Тугаа А/818

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-0614006544
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н.Пүрэвэ /ЖЭ87081310/-гийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-0614006544 дугаарт бүртгэлтэй, Дорнод аймгийн Хэрлэн сум, 4 дүгээр баг, Зангиат 1 дүгээр гудамжны 08 тоот хаягт байрлах хувийн сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-0614006544 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-0614006544 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000347276 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-0614006544 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Ууганчимэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Дорнод аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007069



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 6 өдөр

Дугаар А/849

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Капитрон Банк ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Балын Лхагвасүрэнг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Лхагвасүрэнд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Д.Болормаад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА 
P. СОДХҮҮ

007737



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/850

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н.Уранчимэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянгол дүүргийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Сүхээгийн Оюунболдыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Оюунболдод, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ж.Адилбишд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ

007765



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/551

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Э.Одонтогосын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Самбуугийн Даваадоржийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Даваадоржид, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

РСОДХҮҮ

007769



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/852


Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах тухай

Монгол Улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Тайландын Вант Улсын Бангкок хотоос ирүүлсэн урилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2017 оны 10 дугаар сарын 18-наас 20-ны өдрүүдэд Иргэний бүртгэл, хүн амын ердийн хөдөлгөөний үзүүлэлтийг сайжруулах зорилгоор байгуулагдсан Бүс нутгийн удирдах зөвлөлийн 3 дугаар хуралд тус газрын Тамгын газрын дарга Батжаргалын Бадамцэцэгийг зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцуулсугай.

2. Тус семинарт идэвхитэй оролцож, үр дүнгийн талаар Даргын зөвлөлийн хуралд мэдээлэл хийхийг Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА  Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

№ 77 20 03 13

А/853

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцугай:

1.1. Иргэн Т.Пүрэвсүрэн /СТ66041904/, Б.Түвшинбаяр /СТ81030917/, Г.Алтанзаяа /СВ90092512/, П.Өлзийхутаг /СЮ98113013/, Г.Мөнхцэцэг /СЮ02322307/, Э.Бямба-Очир /СБ05271612/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-1817001547 дугаарт бүртгэлтэй, Хэнтий аймгийн Хэрлэн сум 5 дугаар баг Өндөрхаан Сариг 23 дугаар гудамжны 08 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 00073043 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч О.Нарангаравт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 13 өдөр

Хуудас А/854

Утасны баазын код

Эрхийн улсын бүртгэлийн Y-2101008189
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Д.Бямбасүрэн /ИД77073000/, Г.Нямдаваа /ИЕ67120177/ нарын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-2101008189 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сумын 11 дүгээр баг 49 дүгээр гудамжны 09 тоот хаягт байрлах хувийн сууц нь шатаж устсан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2101008189 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2101008189 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 0074686 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2101008189 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын бүртгэгч Б.Бат-Эрдэнэд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Мөнхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  СОДХҮҮ

007079



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/855

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай:

1.1. Иргэн Т.Мөнхбат /ЗА59031718/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0814002881 дугаарт бүртгэлтэй, Дундговь аймгийн Сайнцагаан сум 9 дүгээр баг Буянт 3-64 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000355906 дугаартай;

1.2. Иргэн П.Оюунцэцэг /ЗА55120808/-ийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-0814002882 дугаарт бүртгэлтэй, Дундговь аймгийн Сайнцагаан сум 9 дүгээр баг Буянт 3-63 тоот хаягт байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000355907 дугаартай;

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичигт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Дундговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



РСОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/856

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн А.Даваажаргалын нэхэмжлэлтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн хяналтын улсын байцаагч Баатарын Энхмэндийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Энхмэндэд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007775



ОЮУНЫ ӨМН, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 17

Дугаар А/57

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцугай.

1.1.иргэн Л.Нямсүрэн /ТЭ67060466/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2004001576 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Орхон сумын 2 дугаар баг, Энхтал Хөтөл 88 дугаар гудамжны 11 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000312129 дугаартай.

1.2.иргэн Г.Пүрэвдорж /ФА51112674/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн У-2003009396 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар баг, 1 дүгээр хороолол 3 дугаар байр, 46 тоот хаягт байрлах, орон сууцны 000132449 дугаартай.

1.3.иргэн Н.Наранбаатар /ТА95091710/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Г-2003007952 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Дархан сумын 18 дугаар баг, Малчин хөтөл 17 дугаар гудамжны 26 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000237246 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007073



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 17

А/208

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсэг, 2016 оны 10 дүгээр сарын 10-ны өдрийн Дархан-Уул аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 01317 дугаартай захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Бүртгэлийн гэрчилгээг 2016 оны 10 дүгээр сарын 10-ны өдрийн Дархан-Уул аймгийн сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 01317 дугаартай захирамж, Дархан-Уул аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны 2017 оны 01/3471 дугаартай албан бичгийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

1.1. иргэн Л.Хишигбаатар /ТЯ68061333/-ын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн У-2001000487 дугаарт бүртгэлтэй, Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан баг, 15 дугаар байр, 51 тоот хаягт байрлах, орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн 0058629 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Дархан-Уул аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Ш.Цэндсүрэнд зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.БОДХҮҮ

007081



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сар 17

Дугаар А/859

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-1603000083
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, Хяналтын улсын байцаагчийн 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 590 дугаартай дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Иргэн А.Хызай /ЛП71010714/, Н.Дамыс /ЛП71021521/, Х.Жахсылых /ПВ92091511/ нарын өмчлөлийн Ховд аймгийн Ховд сумын Улаан бураа багийн долоогийн газар, хар замын арын 2 дугаар гудамжны 08 тоот хаягт байрлах хувийн сууцыг бүртгэж гэрчилгээ олгохдоо Буянт сумын код олгож, улсын бүртгэлийн Y-1603000083 дугаарт бүртгэж гэрчилгээ олгосон болох нь хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдож байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-1603000083 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-1603000083 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000160998 дугаартай гэрчилгээг хүчингүй болсонд тооцугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-1603000083 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Отгонзаяад зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Ховд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007085



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 17

Тусгай А/860

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

1.1. Иргэн Н.Батбаатар /КБ66062718/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-1105003204 дугаарт бүртгэлтэй, Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төв 1 дүгээр баг, Гурвансайхан 12-4 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000222379 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж шинээр гэрчилгээ олгохыг Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Азжаргалд зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007087



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 8/361

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 27 дугаар зүйлийн 27.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ц.Батбилэгийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч Балын Лхагвасүрэнг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Лхагвасүрэнд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Д.Болормаад тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

007777



ОЮУНЫ ӨМН, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/862

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6 "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь.

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэний гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

1.1. Иргэн С.Баянбат /О364121316/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2101003154 дугаарт бүртгэлтэй, Орхон аймгийн Баян-Өндөр сум Хүрэнбулаг баг 4 дүгээр хороолол 16 дугаар байрны 48 тоот хаягт байрлах орон сууцны 0011744 дугаартай.

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Д.Баярмаад зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/063

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2203002582
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ц.Гансүх /УС61080712/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2203002582 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Алтайн 14 дүгээр гудамжны 415 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний газрын өмчлөх эрхээсээ татгалзах хүсэлтийг гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2203002582 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2203002582 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000420316 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-22030025/2 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Н.Анхбаярт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Б.Ариунболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ

007794



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/864

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2203001094,
Г-2203009991, Г-2203002364 дугаарыг хүчингүй
болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Ц.Дашцэрэн /ЕС72052331/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2203001094 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Алтайн 8 дугаар гудамжны 218 тоот, эрхийн улсын бүртгэлийн Г-2203009991 дугаарт бүртгэлтэй Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Алтайн 8 дугаар гудамжны 216 тоот, эрхийн улсын бүртгэлийн Г-2203002364 дугаарт бүртгэлтэй Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, Алтайн 8 дугаар гудамжны 228 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний газруудын өмчлөх эрхээсээ татгалзах хүсэлтийг гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Г-2203001094, Г-2203009991, Г-2203002364 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2203001094, Г-2203009991, Г-2203002364 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000405240, 000405253, 000405241 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2203001094, Г-2203009991, Г-2203002364 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Н.Анхбаярт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга Б.Ариунболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

007796



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/855

Улаанбаатар хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Ц.Оюунчимэгийн нэхэмжлэлтэй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Довчингийн Байгалмааг томилсугай.

1. Ц.Цэрэндолгорын нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тус газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн улсын бүртгэгч Цогтбаатарын Сүмбэрийг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид хуульд заасны дагуу нэхэмжлэлийг гардан авах, эсрэг талын шаардлага, тайлбар, татгалзал, түүнийг нотлох баримттай танилцах, тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, шүүх хуралдаанд оролцох, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, хуурамч нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлсэн, цуглуулсан гэж үзвэл шалгуулах буюу нотлох баримтаас хасуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах, хуульд заасан үндэслэлээр шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, шинжээч, орчуулагч, хэлмэрч, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргыг татгалзан гаргах, шүүх хуралдааны бусад оролцогчдод асуулт тавих, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, шүүхийн шийдвэрийг албадан биелүүлэхийг шаардах эрхийг олгосугай.

3. Итгэмжлэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаанд хүчинтэй болохыг дурдсугай.

4. Хэргийн явцын талаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст тогтмол тайлагнаж ажиллахыг итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Сүмбэрт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ж.Адилбишид тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

P.СОДХҮҮ

008853



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр.

Дугаар А/186

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.1.1 дэх заалт, "Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрэм"-ийн 2.1.2, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 06-ний өдрийн А/186 дугаар тушаалаар байгуулагдсан "Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс"-ын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэлийн төв архив, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн газар хэлтсүүдээс ирүүлсэн 688 хадгаламжийн нэгж, 763930 ширхэг иргэний улсын бүртгэлийн /ИУБ/ маягыг устгах ажлыг зохион байгуулах "Ажлын хэсэг"-ийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Оюунгэрэл
Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга

Гишүүд:

З.Хонгорзул,
Нийслэлийн улсын бүртгэлийн газрын архивын хэлтсийн дарга

Г.Хүчитбаатар
Улсын бүртгэлийн төв архивын ахлах мэргэжилтэн

Б.Ганбаатар
Хяналтын газрын хяналтын улсын ахлах байцаагч

Б.Нарангэрэл
Иргэний бүртгэлийн газрын, гадаад зорчих эрхийн бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч

С.Баярсайхан
Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч

Л.Алтанцэцэг
Мэдээлэл технологийн газрын Мэдээллийн сан, програм хангамжийн

хэлтсийн програм зохиогч

Б.Даваадорж
Улсын бүртгэлийн төв архивын архивч

Нарийн бичгийн дарга:

Ш.Батмаа
Улсын бүртгэлийн төв архивын
мэргэжилтэн

2.Устгалын ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу, "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн хяналтан дор 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг "Ажлын хэсэг"-ийн ахлагч С.Оюунгэрэлд үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт даалгасугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text, including the name of the State Register Center and the date 2017.12.05. The signature is written in a cursive style, crossing the stamp.



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/950

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2205002312
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н Энхцэцэг /УУ85091223/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2205002312 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, Баруун ард Аюушийн 1 дүгээр гудамж 12-1 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2205002312 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2205002312 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000325838 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2205002312 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Г.Содгэрэлд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Н.Гантуяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

006523



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/951

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2205015372 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Н.Энхцэцэг /УУ65091223/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205015372 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, Баруун ард аюушийн 1 дүгээр гудамж 12-1 тоот хувийн сууцны зориулалттай эд хөрөнгийг нурааж буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2205015372 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205015372 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000197923 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2205015372 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Г.Содгэрэлд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Н.Гантуяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

006521



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/952

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2202018553
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Л.Чимгээгийн өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-2202018553 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо, 6 дугаар хороолол /15140/, Их тойруу гудамж 68/1 тоот хаягт байрлах 3935.5 м.кв талбай бүхий 60%-ийн гүйцэтгэлтэй үйлчилгээтэй орон сууцыг иргэн Л.Чимгээгийн ирүүлсэн жагсаалтаар захиалагчдын өмчлөлд салгаж бүртгэгдэж дууссан тул Л.Чимгээгийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2202018553 дугаарыг хүчингүй болгож, үндсэн хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202018553 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000180523 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202018553 дугаартай хувийн хэрэгт бүртгэл болон цахим санд холбогдох бичилт хийж хаахыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэл хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Т.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэгт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СЭДЭН

000898



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/953

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2202010486
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг
бүртгэлийг хаах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Макс Өргөө" ХХК /5046696/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202010486 дугаарт бүртгэлтэй Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Барилгачидын талбай 4/6, 4/7 тоот хаягт байрлах, 11926,7 м.кв талбай бүхий орон сууцыг "Макс Өргөө" ХХК-аас ирүүлсэн жагсаалтаар захиалагчдын өмчлөлд салгаж бүртгэж байгаа тул "Макс Өргөө" ХХК-ний гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2202010486 дугаарыг хүчингүй болгож, үндсэн хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202010486 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улын бүртгэлийн 00043675 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2202010486 дугаартай хувийн хэрэг бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч М.Оюундэлгэрт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн дарга М.Ганчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Р.СОДХҮҮ

000900



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/954

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001764
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Ч.Эрдэнэбат /ЦБ77040176/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204001764 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо, Эмнэлэг 25 дугаар гудамжны 610 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул өмчлөгчийн хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204001764 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001764 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000466979 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204001764 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Б.Хөлгөнд зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

006653



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/955

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2204003691
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31.1.2 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Иргэн Д.Самбууням /АЭ86032676/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204003691 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, 3Б хэсэг улиастай гудамжны 516 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын өмчлөх эрхээсээ татгалзсан байх тул өмчлөгчийн хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2204003691 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204003691 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000467219 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2204003691 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Б.Булгантамирт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

006649



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/956

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y2204021444
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
улсын бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэн Ш.Есөн-Эрдэнэ /PE70051379/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204021444 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, Жанжин 25 дугаар гудамж 613 тоот хаягт байрлах, хувийн сууцны зориулалттай барилгаа нурааж, буулгасан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Y-2204021444 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг бүртгэлийг хаасугай.

2.Эрхийн улсын бүртгэлийн Y-2204021444 дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн 000120996 дугаартай гэрчилгээг хүчингүй болгосугай.

3.Эрхийн улсын бүртгэлийн Y-2204021444 дугаартай хувийн хэрэг, улсын бүртгэлд холбогдох бичилт хийж, хаахыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч М.Лхагвасүрэнд зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч М.Батцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/95Т

Улаанбаатар хот

Хуралд оролцуулах тухай

Монгол Улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас ирүүлсэн урилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон Улсын Санхүүгийн Корпораци болон Филиппин улсын Сангийн яам хамтран Манила хотноо 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулах "Хөдлөх хөрөнгө барьцаалсан санхүүжилтээр дамжуулан жижиг дунд бизнесүүдийг дэмжих нь" сэдэвт олон улсын хуралд тус газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Жаргалсайханы Норжинг зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцуулсугай.

2. Тус хуралд идэвхтэй оролцож, тайланг Тамгын газарт ирүүлэхийг Ж.Норжинд үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ

008865



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/958

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70,71 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй биет хөрөнгө болох үндсэн хөрөнгө /компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, авто тээврийн хэрэгсэл/, бараа материал /аж ахуй эд хогшил, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, үнэт цаас маягт, хангамжийн материал/ мөн биет бус хөрөнгийг тоолох жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий "Ажлын хэсэг"-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Д.Дэлгэрсайхан
/Дэд дарга/

Гишүүд:

В.Мөнгөнсүх
/Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах
мэргэжилтэн/

Э.Оюунцэцэг
/Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах
нягтлан бодогч/

Д.Наранбаатар
/Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн
мэргэжилтэн/

Б.Өзлүн-Үжин
/Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод
аудитын газрын мэргэжилтэн/

Д.Батбаяр
/Мэдээллийн технологийн газрын
мэдээллийн сангийн системийн
зохицуулагч /

Б.Баясгалан
/Мэдээллийн технологийн газрын

2. Жилийн эцсийн тооллогод тоолуулах бэлтгэл ажлыг хууль тогтоомжийн дагуу 2017 оны 12 дугаар сарын 4-ны өдрийн дотор хангаж ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Ч. Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

3. "Тооллогын ажлын удирдамж"-ийг нэгдүгээр, "Тооллогын ажлын төлөвлөгөө"-г хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

4. Тооллогын ажлыг батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу 2017 оны 12дугаар сарын 04-ны өдрөөс эхлэн зохион байгуулан ажиллаж дүнг 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн дотор танилцуулахыг "Ажлын хэсэг"-ийн ахлагч Д.Дэлгэрсайханд даалгасугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

инженер/

О.Ганболор

/Иргэний бүртгэл, гадаад паспортын газрын бүртгэгч оператор/

Ж.Нямдорж

/Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч/

Б.Галбадрах

/Бүртгэлийн хяналтын газрын хяналтын улсын байцаагч/

Б.Авирмэд

/Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын улсын бүртгэгч/

Б.Даваадорж

/Улсын бүртгэлийн төв архивын газрын архивч/

П.Батбилэг

/Хүний нөөц, сургалтын хэлтсийн мэргэжилтэн/

Ц.Болормаа

/Санхүү, аж ахуйн хэлтсийн тооцооны нягтлан бодогч/

А.Наранцэцэг

/Санхүү, аж ахуйн хэлтсийн тооцооны нягтлан бодогч /

Б.Гантулга /Иргэний баримтын архивын газрын архивч/

Ч.Мягмар

/Санхүү, аж ахуйн хэлтсийн нярав/

Ч.Мөнхцэцэг

/Санхүү, аж ахуйн хэлтсийн нярав/

С.Баярсайхан

/Санхүү, аж ахуйн хэлтсийн тооцооны нягтлан бодогч/

Ц.Ганчимэг

/Санхүү, аж ахуйн хэлтсийн тооцооны нягтлан бодогч/

Нарийн бичгийн дарга

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ТООЛЛОГЫН АЖЛЫН УДИРДАМЖ

Тооллогын ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах удирдамжийг хэрэгжүүлэн ажиллах ба тухайн тоолсон ажлын хэсгийн гишүүд баталгаажуулан тооллогын ажлын баримтыг "Ажлын хэсэг"-ийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.

Тооллого хийлгэхэд хариуцаж ажиллах албан тушаалтан нь дараах үүрэгтэй.

Үүнд:

-Тухайн тооллого явуулах хэсгийн албан хаагчдыг эд хөрөнгөө тооллогонд бүрэн хамруулах ба тооллого хийх үед албан хаагчдыг ажлын байранд бүрэн байлгах талаар онцгойлон анхаарна.

-Хамрагдах хэсгийн эд хөрөнгийн тооллогын үед биечлэн оролцоно.

-Тооллогын ажлын хэсгийн гишүүдийг тооллогын ажлыг явуулах нөхцөл бололцоогоор бүрэн хангана.

-Тооллогоор ажиллаж байгаа ажлын хэсгийн гишүүд тооллого явуулах үед дараах зүйлсийг анхаарч хэрэгжүүлж ажиллана. Үүнд:

1. Албан хаагчдын ашиглаж байгаа эд хөрөнгийн тооллогоор:

-Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер, принтер, хувилагч гэх мэт техник хэрэгсэл, ширээ, сандал, бусад хогшлыг төслөөр болон байгууллагын хөрөнгөөр бий болсноор /шинэ, хуучин/ ангилна.

-Техник хэрэгслийг марк шинж чанараар бүртгэнэ.

-“Ширээ”-г шургуулагатай тусдаа шургуулагатай, “сандал”-ыг эргэдэг, эргэдэггүй, дарга сандал гэх мэтээр ангилж бүртгэнэ.

-Эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх ба /картын өгөгдлийг бүрэн зохих журмын дагуу бөглөсөн байна. Эд хариуцагчаар гарын үсэг зуруулсан байна.

-Хэрэв эд хариуцагч нь удаан хугацаагаар эзгүй байгаа бол эд хөрөнгийг тухайн албан хаагчийн нэгжийн даргад бүртгэж шинээр картжуулж, баталгаажуулна./хуучин картыг хавсаргасан байна/

-Тухайн албан тасалгаанд байгаа хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлэх талаар онцгойлон анхаарна.

-Тухайн нэгжид гэрээтээр ажиллаж байгаа албан хаагчдад тухайн ашиглаж байгаа эд хөрөнгийг хариуцуулж эд хөрөнгийг картжуулах ба /картын өгөгдлийг бүрэн бөглөсөн байна/ эд хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна.

-Албан хаагчдийн ашиглахгүй бүртгэлтэй байгаа хөрөнгийг хураан авч, “Эд хариуцагчаас ашиглахгүй байгаа хөрөнгийн хураан авсан болон шилжүүлсэн баримт /акт/-ыг үйлдэн хавсаргана. Тухайн хөрөнгийн жагсаалтыг тусад нь гаргаж ирүүлэх бөгөөд картаас хасалт хийнэ.

2. Тухайн байранд ашиглагдаж байгаа эд хөрөнгийн тооллогоор:

-Уг байранд ашиглагдаж байгаа эд хөрөнгийг мөн төслөөр болон байгууллагын

хөрөнгөөр бий болсноор ангилна.

-Эд хөрөнгийн нэр марк шинж чанараар бүртгэнэ.

-Тухайн байранд ажиллаж байгаа тодорхой албан тушаалтан болон няравын картанд давхар бүртгэлжүүлнэ. /давхар бүртгэсэн тухайгаа тэмдэглэл үйлдэнэ./

-Цаашид солих шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг тусад нь гаргаж ирүүлнэ.

-Ашиглагдахгүй байгаа хөрөнгийг хураан авч, "Эд хариуцагчаас ашиглахгүй байгаа хөрөнгийн хураан авсан болон шилжүүлсэн баримт "акт"-ыг үйлдэн хавсаргана. Тухайн хөрөнгийн жагсаалтыг тусад нь гаргаж ирүүлэх бөгөөд эд хөрөнгө ашиглалтын картанд бүртгэлтэй байгаа бол хасалт хийнэ.

3. Дүүрэгт ашиглаж байгаа эд хөрөнгийн тооллогоор:

-Албан хаагчдын /эд хөрөнгийн бүртгэгч, ерөнхий газраас шилжиж ажиллаж байгаа/ ашиглаж байгаа компьютер, принтер хувилагч гэх мэт техник хэрэгсэл, ширээ, сандал, бусад хогшлыг төслөөр авсан болон ерөнхий газраас хуучин ашиглаж байсан шинээр бий болсон зэргээр ангилна.

-Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.

-“Ширээ”-г шургуулагатай тусдаа шургуулагатай, “сандал”-ыг эргэдэг, эргэдэггүй, дарга сандал гэх мэтээр ангилж бүртгэнэ.

-Эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх ба /картын өгөгдлийг бүрэн зохих журмын дагуу бөглөсөн байна. Эд хариуцагчаар гарын үсэг зуруулсан байна.

-Хэрэв эд хариуцагч нь удаан хугацаагаар эзгүй байгаа бол эд хөрөнгийг тухайн албан хаагчийн нэгжийн даргад бүртгэж шинээр картжуулж, баталгаажуулна./хуучин картыг хавсаргасан байна/

-Тухайн албан тасалгаанд байгаа хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлэх талаар онцгойлон анхаарна.

-Тухайн нэгжид гэрээтээр ажиллаж байгаа албан хаагчдад тухайн ашиглаж байгаа эд хөрөнгийг хариуцуулж эд хөрөнгийг картжуулах ба /картын өгөгдлийг бүрэн бөглөсөн байна/ эд хариуцагчаар гарын үсэг зуруулна.

4.Серверийн өрөө болон иргэний цахим үнэмлэхний үйлдвэрийн эд хөрөнгийн тооллогоор:

-Тухайн хэсэгт байгаа сервер, тоног төхөөрөмж, компьютер, принтер, хувилагч гэх мэт бусад техник хэрэгсэл, ширээ сандал бусад хогшлыг төслөөр авсан болон ерөнхий газраас хуучин ашиглаж байсан шинээр бий болсон зэргээр ангилна.

-Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.

-Өндөр үнэтэй сервер тоног төхөөрөмжийг картжуулна. /бий болсон эх үүсвэр, ашиглалтад орсон огноо, хүчин чадал, гарал үүсэл марк гэх мэт/

-“Ширээ”-г шургуулагатай тусдаа шургуулагатай, “сандал”-ыг эргэдэг, эргэдэггүй, дарга сандал гэх мэтээр ангилж бүртгэнэ.

-Эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх ба /картын өгөгдлийг бүрэн зохих журмын дагуу бөглөсөн байна. Эд хариуцагчаар гарын үсэг зуруулсан байна.

5. Дата төвд байрлах эд хөрөнгийн тооллогоор:

-Тухайн хэсэгт нэвтрэх эрх, зөвшөөрлийг тусгайлан бэлтгэсэн байна.

-Сервер, тоног төхөөрөмж, компьютер техник хэрэгслийг төслөөр авсан болон ерөнхий газраас хуучин ашиглаж байсан, шинээр бий болсон зэргээр ангилна.

-Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.

-Өндөр үнэтэй сервер тоног төхөөрөмжийг картжуулна. /бий болсон эх үүсвэр, ашиглалтад орсон огноо, хүчин чадал, гарал үүсэл марк гэх мэт/

6. Архивын /фондын/ хэсэгт байрлах эд хөрөнгийн тооллогоор:

-Архивын сейф, тоног төхөөрөмж,бусад эд хогшлийг төслөөр авсан болон ерөнхий газраас хуучин ашиглаж байсан, шинээр бий болсон зэргээр ангилна.

-Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.

-Архивын фондод байрлах эд хөрөнгийг хуучин бүртгэлтэй байсан ажилтанд мөн хариуцуулах ба эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх, /картын өгөгдлийг бүрэн бөглөсөн байна/ эд хариуцагчаар гарын үсэг зуруулна.

7.Иргэний шинэчилсэн бүртгэлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооллогоор:

-Санхүү,аж ахуйн хэлтсээр агуулахад байгаа, ерөнхий газарт ашиглаж байгаа, гадаад оронд ашиглаж байгаа болон дансанд тусгасан бүртгэлийг тус тус урьдчилан бэлтгүүлсэн байна.

-Агуулахад байгаа болон албан хаагчдын ашиглаж байгаа иргэний шинэчилсэн бүртгэлтэй холбоотой эд хөрөнгийг нэг бүрчлэн тоолж бүртгэнэ.

-Гадаад оронд ашиглаж байгаа төхөөрөмжийн бүртгэлийг тухайн оронд ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор ГХЯ-нд албан тоотыг хүргүүлсэн байна.

8. Сонгуулийн бүртгэлийн техник хэрэгслийн эд хөрөнгийн тооллогоор:

-Бүртгэлийн техник хэрэгсэлд байх иж бүрдлийг /цүнх, зөөврийн компьютер, хулгана, цэнэглэгч, хурууны хээ уншигч, уртасгагч/ нэг бүрчлэн тоолж бүртгэнэ.

-Зөөврийн принтерт байх иж бүрдлийг /цүнх, принтер, цэнэглэгч/ нэг бүрчлэн тоолж бүртгэнэ.

-Свич, карт уншигч болон тухайн агуулахад байгаа бусад эд хөрөнгийг тооллогод хамруулна.

9. Авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбоотой эд зүйлсийн тооллогоор:

-Санхүү,аж ахуйн хэлтсээр тухайн 2017 онд шинээр бий болсон болон дансанд тусгасан бусад эд зүйлсийн бүртгэлийг тус тус урьдчилан бэлтгүүлсэн байна.

-Тухайн жолоочийн хариуцаж байгаа автомашинд байх ёстой бичиг баримт, дугуй, суудлын бүрээс, ачаа дуут дохио, станц гэх мэт бусад эд зүйлсийг нэг бүрчлэн тоолж, бүртгэнэ.

-Тооллого хийсэн үед тухайн автомашины өнгө үзэмж, гадна талын сэв, дотор талын салонд болон шаардлага хангахгүй сольж, сэлбэхээр болсон эд ангийн байдал,спидометрийн заалтыг тусгайлан бүртгэж баримтжуулна.

10. Агуулахад ашиглагдахгүй байгаа эд хөрөнгө эд зүйлсийн тооллогоор:

-Агуулах болон бусад газарт ашиглалтгүй болсон эд хөрөнгийн жагсаалтыг үйлдэнэ.

-Ашиглалтгүй болсон эд хөрөнгийг ашиглаж байсан эд хариуцагчийг олж тогтоож, эд хөрөнгө ашиглалтын картнаас хасалт хийх болон эзэмшигчийн буруугаас болсон эсэхийг тогтоож бүртгэнэ.

-Агуулахад байгаа ашиглаж болох болон агуулж байгаа бусад эд зүйлсийг нэг бүрчлэн тоолж, тусад нь бүртгэнэ.

11. Биет бус хөрөнгө буюу програм хангамжийн тооллогоор:

- Дансанд тусгасан бүртгэлийг болон уг биет бус хөрөнгө хаана ашиглагдаж байгаа талаарх мэдээллийг Санхүү, аж ахуйн хэлтэс, Мэдээллийн технологийн газраар тус тус урьдчилан бэлтгүүлсэн байна.

-Ашиглаж байгаа ашиглалтгүй болсон програм хангамж, биет бус хөрөнгийн мэдээллийг тусгайлан бэлтгэсэн маягтын дагуу бөглөж ирүүлнэ.

12. Барга материалын тооллогоор:

-Санхүү, аж ахуйн хэлтсээс 2017 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаарх эргэлтийн хөрөнгийн данс бүртгэлийн үлдэгдлийг хариуцсан нярав, үнэт цаас зарцуулагч бүрээр гаргуулж, баталгаажуулан урьдчилан бэлтгүүлсэн байна.

-Нярав бүрээр агуулахад байгаа үнэт цаас, маягтыг нэг бүрчлэн тоолж, бүртгэж үлдэгдэлтэй нь тулган баталгаажуулна.

-Бүртгэгч бүрээр үнэт цаас, маягтыг нэг бүрчлэн тоолж, бүртгэж, үлдэгдэлтэй нь тулган баталгаажуулна.

-Нярав бүрээр агуулахад байгаа хангамжийн материалыг нэг бүрчлэн тоолж, бүртгэж үлдэгдэлтэй нь тулган баталгаажуулна.

-Нярав бүрээр агуулахад ашиглалтгүй байгаа хангамжийн материалаас бусад эд зүйлсийг нэг бүрчлэн тоолж, бүртгэж үлдэгдэлтэй нь тулган баталгаажуулна.

-Нярав бүрээр агуулахад ашиглалтгүй байгаа бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг нэг бүрчлэн тоолж, бүртгэж, үлдэгдэлтэй нь тулган баталгаажуулна.

-Мал амьтадыг газар дээр нь очиж нэг бүрчлэн үзэж тоолж, бүртгэлжүүлэн баталгаажуулна.

13. "Койка"-ийн төслийн хүрээнд бий болсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооллогоор:

-Албан хаагчдын ашиглаж байгаа төслөөр авсан компьютер, принтер хувилагч гэх мэт техник хэрэгсэл, ширээ, сандал, бусад хогшлыг нэг бүрчлэн бүртгэнэ.

-Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.

-Эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх ба /картын өгөгдлийг бүрэн зохих журмын дагуу бөглөсөн байна. Эд хариуцагчаар гарын үсэг зуруулсан байна.

-Хэрэв эд хариуцагч нь удаан хугацаагаар эзгүй байгаа бол эд хөрөнгийг тухайн албан хаагчийн нэгжийн даргад бүртгэж шинээр картжуулж, баталгаажуулна./хуучин картыг хавсаргасан байна/

-Тухайн албан тасалгаанд байгаа хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлэх талаар онцгойлон анхаарна.

-Тухайн нэгжид гэрээтээр ажиллаж байгаа албан хаагчдад тухайн ашиглаж байгаа эд хөрөнгийг хариуцуулж эд хөрөнгийг картжуулах ба /картын өгөгдлийг бүрэн бөглөсөн байна/ эд хариуцагчаар гарын үсэг зуруулна.

14. Монголын мянганы сорилтын сангийн хөрөнгийн эрхийн төслийн хүрээнд бий болсон техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооллогоор:

- Албан хаагчдын ашиглаж байгаа төслөөр авсан компьютер, принтер хувилагч гэх мэт техник хэрэгсэл, ширээ, сандал, бусад хогшлыг нэг бүрчлэн бүртгэнэ.
- Техник хэрэгслийн марк шинж чанараар бүртгэнэ.
- Эд хөрөнгө ашиглалтын картыг шинэчлэх ба /картын өгөгдлийг бүрэн зохих журмын дагуу бөглөсөн байна. Эд хариуцагчаар гарын үсэг зуруулсан байна.
- Хэрэв эд хариуцагч нь удаан хугацаагаар эзгүй байгаа бол эд хөрөнгийг тухайн албан хаагчийн нэгжийн даргад бүртгэж шинээр картжуулж, баталгаажуулна./хуучин картыг хавсаргасан байна/
- Тухайн албан тасалгаанд байгаа хөрөнгийг бүрэн бүртгэлжүүлэх талаар онцгойлон анхаарна.
- Тухайн нэгжид гэрээтээр ажиллаж байгаа албан хаагчдад тухайн ашиглаж байгаа эд хөрөнгийг хариуцуулж эд хөрөнгийг картжуулах ба /картын өгөгдлийг бүрэн бөглөсөн байна/ эд хариуцагчаар гарын үсэг зуруулна.

15. Тооллогын дүнг нэгтгэх асуудлаар:

- Санхүү, аж ахуйн халтсийн тухайн тооллогод хамрагдах үеийн эд хөрөнгийн данс бүртгэлийн үлдэгдлийг гарган баталгаажуулж "Ажлын хэсэг"-ийн нарийн бичгийн даргад ирүүлнэ.
- Тооллогын ажлын төлөвлөгөөний дагуу тоолсон баримтыг ажлын хэсгийн гишүүдээс авч, гарын үсэг зурсан болон ажлын удирдамжийн дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьж, бүрэн гүйцэд биш үед буцааж бүрдлийг хангаж ажиллана.
- Тооллогын дүнг нэгтгэн, данс бүртгэлтэй тулгаж, илүү, дутууг гарган бүртгэлийг хөтөлж, илтгэх хуудсаар танилцуулга бэлтгэнэ.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017 оны дугаар тушвалын хоёрдугаар хавсралт



ТООЛЛОГЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Тооллогод хамрагдах хөрөнгийн нэр, хийгдэх ажил	Тооллого явуулах хугацаа	Тооллого хийлгэхэд хариуцаж ажиллах албан тушаалтан	Тооллого хийх ажлын хэсгийн гишүүд
1. ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТООЛЛОГЫН ХҮРЭЭНД				
1.1	Ерөнхий газрын 1-р байранд ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.04-2017.12.06	Иргэний бүртгэлийн газрын дарга	О.Ганболор Б.Галбадрах Ч.Мөнхцэцэг
1.2	Ерөнхий газрын 2-р байранд ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.07-2017.12.08	Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга	А.Наранцэцэг Б.Даваадорж Ч.Мөнхцэцэг
1.3	Ерөнхий газрын 3-р байранд ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.11-2017.12.13	Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга	Ц.Ганчимэг Ж.Нямдорж Ч.Мөнхцэцэг
1.4	Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн архивын эд хогшил	2017.12.14-2017.12.15	Улсын бүртгэлийн төв архивын газрын дарга	С.Баярсайхан Ж.Нямдорж Ч.Мөнхцэцэг
1.5	Ерөнхий газрын төв байранд ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.11-2017.12.12	Тамгын газрын дарга	Б.Өзлүн-Үжин П.Батбилэг Ч.Мягмар

1.6	Серверийн өрөөний техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад эд зүйлс	2017.12.11- 2017.12.12	Мэдээллийн технологийн газрын дарга	С.Баярсайхан Г.Баясгалан
1.7	Иргэний үнэмлэхийн үйлдвэрийн компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.12 2017.12.13	Мэдээллийн технологийн газрын дарга	Д.Наранбаатар Ц.Болормаа
1.8	Дүүргийн эд хөрөнгийн бүртгэлийн нэгжид ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.14- 2017.12.21	Дүүргийн хэлтсийн дарга, эд хөрөнгийн бүртгэлийн тасгийн дарга нар	С.Баярсайхан Ц.Болормаа А.Наранцэцэг Ч.Мөнхцэцэг
1.9	Дата төвд ашиглаж байгаа серверийн тоног төхөөрөмж	2017.12.22	Мэдээллийн технологийн газрын дарга	С.Баярсайхан Г.Баясгалан
1.10	Сонгуулийн бүртгэлийн техник хэрэгсэл	2017.12.25- 2017.12.29	Бүртгэлийн хяналтын газрын дарга	С.Баярсайхан Г.Баясгалан Ч.Мөнхцэцэг
1.11	Авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбоотой эд зүйлс	2017.12.11- 2017.12.12	Тамгын газрын дарга	В.Мөнгөнсүх А.Наранцэцэг
1.12	Иргэний шинэчилсэн бүртгэлийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	2018.01.02	Санхүү, аж ахуйн хэлтсийн ахлах нягтлан бодогч	С.Баярсайхан Г.Баясгалан Ч.Мягмар
1.13	Агуулахад ашиглагдахгүй байгаа эд хөрөнгө	2017.12.18- 2017.12.19	Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга	С.Баярсайхан Ч.Мөнхцэцэг Ч.Мягмар
1.14	Биет бус хөрөнгө буюу програм хангамж	2017.12.04- 2017.12.06	Мэдээллийн технологийн газрын дарга	С.Баярсайхан Д.Батбаяр

1.15	Оюуны өмчийн байранд ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, бусад эд зүйлс	2017.12.07- 2017.12.08	Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга	Б.Гантулга В.Мөнгөнсүх
2. БАРАА МАТЕРИАЛЫН ТООЛЛОГЫН ХҮРЭЭНД:				
2.1	Кассд байгаа бэлэн мөнгө, шатахуун талон	2017.12.25	Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга	Б.Өзлүн-Үжин Э.Оюунцэцэг
2.2	Нярав Ч.Мягмарийн хариуцаж байгаа үнэт цаас маягт	2017.12.04- 2017.12.08		Д.Наранбаатар Б.Галбадрах Ц.Ганчимэг
2.3	Нярав Ч.Мөнхцэцэгийн хариуцаж байгаа үнэт цаас маягт	2017.12.18 2017.12.19		Б.Галбадрах Ц.Ганчимэг Ч.Мөнхцэцэг
2.4	Нярав Ч.Мөнхцэцэгийн хариуцаж байгаа хангамжийн материал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2017.12.20- 2017.12.24		С.Баярсайхан Ж.Нямдорж О.Ганболор
2.5	Нярав Ч.Мягмарийн хариуцаж байгаа хангамжийн материал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2017.12.11- 2017.12.12		С.Баярсайхан О.Ганболор
2.6	Бүртгэгч нарын гар дээр байгаа үнэт цаас, маягт	2017.12.11- 2017.12.13		Ц.Ганчимэг Б.Галбадрах
2.7	Оюуны өмчийн байранд ашиглаж байгаа үнэт цаас, хангамжийн материал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	2017.12.27- 2017.12.28		Б.Гантулга А.Наранцэцэг Ц.Болормаа
2.8	Мал амьтад	2017.12.29		В.Мөнгөнсүх С.Баярсайхан Ч.Мөнхцэцэг

3. ТООЛЛОГЫН ДҮНГ НЭГТГЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

3.1	Тооллого хийсэн тухай баримтыг нэгтгүүлэх	2017.12.20- 2018.01.02		Ажлын хэсгийн гишүүд
3.2	Тооллогын дүнг тулгах, илтгэх хуудас бичих	2018.01.03 2018.01.16		С.Баярсайхан Ц.Ганчимэг
3.3	Тооллогын дүнг удирдлагад танилцуулах	2018.01.17		Д.Дэлгэрсайхан С.Баярсайхан Ц.Ганчимэг

--- оОо ---

ЭД ХАРИУЦАГЧААС АШИГЛАХГҮЙ БАЙГАА ХӨРӨНГИЙГ
ХУРААН АВСАН БОЛОН ШИЛЖҮҮЛСЭН БАРИМТ АКТ

Огноо: _____

Эд хариуцагчийн нэр: _____

Эд хариуцагчийн харьяалах газар хэлтсийн нэр: _____

Эд хөрөнгийн нэр, тоо ширхэг: _____

Эд хөрөнгийн марк, шинж чанар _____

Эд хөрөнгийг хураалгах, шилжүүлэх болсон шалтгаан /эвдрэл, эсхүл өөр
бусад/ _____

Тухайн үед байлцсан ажлын хэсгийн гишүүний нэр: _____

Нягтлан бодогч, няравын нэр _____



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/959

Улаанбаатар хот

Хуралд оролцуулах тухай

Монгол Улсын "Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, ОХУ-ын Эдийн Засгийн Хөгжлийн Яамны харьяа Улсын бүртгэл, кадастр, зураг зүйн газраас ирүүлсэн урилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ОХУ-ын Эдийн Засгийн Хөгжлийн Яамны харьяа Улсын бүртгэл, кадастр, зураг зүйн газартай байгуулсан хамтын ажиллагааны тухай санамж бичгийн хүрээнд 2017 оны 11 дүгээр сар 28-наас 29-ний өдрүүдэд Улаан-Үд хотод зохиогдох уулзалтад тус газрын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Дамбажавын Батболд, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хэлтсийн дарга Пэрэнлэйн Ганзориг, Чингэлтэй дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Эрдэнэцогтын Сувд-Эрдэнэ, Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Сүрэнхоролын Баттөр, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн Загдын Алтанчимэг нарыг оролцуулсугай.

2. Тус хуралд идэвхтэй оролцож, үр дүнгийн талаар Даргын зөвлөлийн хуралд мэдээлэл хийхийг Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Д.Батболд, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хэлтсийн дарга П.Ганзориг нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/960

Улаанбаатар хот

Эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн
гэрчилгээг хүчингүй болсонд тооцох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6, "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам"-ын 10.1, 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүртгэлийн гэрчилгээг хаясан, үрэгдүүлсэн тухай нотлох баримт, иргэдийн гаргасан хүсэлтийг үндэслэн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн дараах гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай. Үүнд:

1.1.Иргэн Ш.Эрдэнэхүү /ХЖ84032910/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2205022906 дугаарт бүртгэлтэй, Баянгол дүүргийн 8 дугаар хороо, Чингүнжавын гудамж 25/3 дугаар байр, 1 дүгээр орц 903 тоот, орон сууцны 000232506 дугаартай;

1.2.Иргэн Л.Ганчимэг /ЙЮ83032906/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2204016879 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо, Эмнэлгийн 5 дугаар гудамж, 321 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000116947 дугаартай;

1.3.Иргэн Л.Ганчимэг /ЙЮ83032906/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204043852 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 17 дугаар хороо, Эмнэлгийн 5 дугаар гудамж, 321 тоот хаягт байрлах, хувийн сууцны 000215478 дугаартай;

1.4.Иргэн Ц.Алгирмаа /ЦБ68031982/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204018790 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Төгөл хус 14 дүгээр байр, 8 тоот, орон сууцны 000418669 дугаартай;

1.5.Иргэн А.Цэрэнбадам /УК98121101/, Ч.Алтангэрэл /Ц361102077/, Б.Саранцэцэг /ФЖ71051001/, Б.Батцэцэг /ФА90021024/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204017853 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Улаанхуарангийн 4 дүгээр гудамж, 139 тоот хаягт байрлах, хувийн сууцны 000191548 дугаартай;

1.6.Иргэн Л.Баттөмөр /ЦВ49082069/, Г.Буян /ЦВ80070668/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204006577 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, 15 дугаар хороолол, 10 дугаар байр, 52 тоот, орон сууцны 000086604 дугаартай;

006777

1.7. Иргэн Ц.Мөнгөнчимэг /ИЮ90011601/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2204030763 дугаарт бүртгэлтэй, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө гудамж, 44/б дугаар байр, 120 тоот, орон сууцны 000391370 дугаартай;

1.8. Иргэн С.Түвшинтөр /УД75091973/, О.Золзаяа /М380090301/, Т.Дашнамжил /УД01260817/, Т.Дашдаваа /УД02300718/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2207000202 дугаарт бүртгэлтэй, Налайх дүүргийн 4 дүгээр хороо, Нисэх 16 дугаар гудамж, 3 А тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000046749 дугаартай;

1.9. Иргэн Э.Болд /СЖ93012310/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2203031093 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, 100 айл гудамж, 65 Б тоот, орон сууцны 000372411 дугаартай;

1.10. Иргэн Э.Одхүү /ЕЭ86010471/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2203008085 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Ногоон талбай 6 дугаар гудамж, 8 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000420006 дугаартай;

1.11. Иргэн Э.Одхүү /ЕЭ86010471/-гийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2203025625 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Ногоон талбай 6 дугаар гудамж, 8 тоот хаягт байрлах, хувийн сууцны 000509401 дугаартай;

1.12. Иргэн Э.Оюунбагана /ХД81080922/, Э.Отгонбагана /ХИ87102463/, Н.Эрдэнэбилэг /ХД55112312/, П.Өлзийхишигт /ХИ56061463/ нарын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2202007266 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо, Хайлааст 12 дугаар гудамж, 254 тоот, хаягт байрлах хувийн сууцны 00087139 дугаартай;

1.13. Иргэн Г.Янжиндулам /ЖЯ59080561/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2202005261 дугаарт бүртгэлтэй, Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо, Зүрх уулын 3 дугаар гудамж, 571 тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 261680 дугаартай;

1.14. Иргэн Н.Солонгоцацралт /НН93100700/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2206007375 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Бурхант 1-4 дүгээр гудамж, 54а тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000349182 дугаартай;

1.15. Иргэн Н.Солонгоцацралт /НН93100700/-ын өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2206008652 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, Бурхант 1-4 дүгээр гудамж, 53а тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000349181 дугаартай;

1.16. Иргэн М.Болор-Эрдэнэ /УУ92062204/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2206005524 дугаарт бүртгэлтэй, Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, Буянт ухаа 7 дугаар гудамж, 288 а тоот хаягт байрлах, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрын 000260436 дугаартай;

2. Дээр дурдсан эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцсонтой холбогдуулан хувийн хэрэг, бүртгэлд зохих бичилт хийж, шинээр гэрчилгээ олгохыг холбогдох дүүргүүдийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г. Анхныбаяр, хүчингүйд тооцсон гэрчилгээг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газрын дарга Б. Бадамцэцэг нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/961

Улаанбаатар хот

Зардал гаргах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хууль зүйн сайдын 2017 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 12 дугаар шуурхай хуралдааны үүрэг даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын хэмжээнд гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн тул ажилчин албан хаагчдын нэг өдрийн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн дэмжлэг болох 5,770,893 төгрөгийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн сангийн 100900012415 тоот дансанд төвлөрүүлсүгэй.

2. Дээрх зардлыг цалин хөлсний зардлаас гаргахыг Тамгын газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА СОДХҮҮ

008062



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/962

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4, Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 4.1.1, 22.1, 45.1, 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагаанд шаардлагатай техник хэрэгсэл, програм хангамж нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

Д.Дэлгэрсайхан
Дэд дарга

Гишүүд:

С.Чинбат
Мэдээллийн технологийн газрын дарга

Ч.Хүрэлбаатар
Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга

О.Тунгалаг
Мэдээлэл, сүлжээ, техникийн хэлтсийн дарга

П.Нэргүй
Мэдээллийн сан, програм хангамжийн хэлтсийн дарга

Х.Цогтбаатар
ХЗДХЯ-ны СХОХ-ийн ахлах нягтлан бодогч

Д.Төрмөнх
Монгол мэргэдийн уламжлал төрийн бус байгууллагын тэргүүн

Э.Жавхлан
Худалдан авах ажиллагааны сургалт,
зөвлөгөө төрийн бус байгууллагын ажилтан


Нарийн бичгийн дарга

Ж.Номин-Эрдэнэ
Мэдээллийн технологийн газрын
мэргэжилтэн

2.Бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг "Үнэлгээний хороо"-ны дарга Д.Дэлгэрсайханд даалгасугай.

3.Үнэлгээний хорооны үйл ажиллагаа болон бараа бүтээгдэхүүн худалдан авалтад хяналт тавьж, үр дүнг төсвийн захирагчид танилцуулж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Гантөмөрт уурэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/963

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Г-2205000178,
Г-2205000179, Г-2205000219, Г-2205003769,
Г-2205000974, Г-2205002283 дугааруудыг
хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэн Б.Ариунболд /ШБ67103119/ нь өөрийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Г-2205000178, Г-2205000179, Г-2205000219, Г-2205003769, Г-2205000974, Г-2205002283 дугааруудад бүртгэлтэй, Баянгол дүүргийн 11 дүгээр хороо, Баруун тасган 2 дугаар гудамж, 21, 22, 23, 23а, 25, 25б тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газруудын өмчлөх эрхээс татгалзсан байх тул өмчлөгчийн гаргасан хүсэлтийн дагуу эрхийн улсын бүртгэлийн Г-2205000178, Г-2205000179, Г-2205000219, Г-2205003769, Г-2205000974, Г-2205002283 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хаасугай.

2. Эрхийн улсын бүртгэлийн Г-2205000178, Г-2205000179, Г-2205000219, Г-2205003769, Г-2205000974, Г-2205002283 дугааруудыг хүчингүй болгож, хувийн хэрэг, бүртгэлийг хааж байгаатай холбогдуулан өмчлөх эрхийн 000261283, 000313633, 000313635, 000313670, 000313634, 000086923 дугаартай гэрчилгээнүүдийг хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Г-2205000178, Г-2205000179, Г-2205000219, Г-2205003769, Г-2205000974, Г-2205002283 дугаартай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн улсын бүртгэгч Г.Содгэрэлд зөвшөөрсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Н.Гантуяа нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,



P.СОДХҮҮ

006525



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/964

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2203004044,
Y2203004506 дугааруудыг хүчингүй болгож,
Y-2203003515 дугаартай бүртгэлд нэгтгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Атимос трейд" ХХК /2637847/-ийн өмчлөлийн, эрхийн улсын бүртгэлийн Y-2203004044 дугаарт бүртгэлтэй, Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, Бага тойруу, 21 дүгээр байрны 25 тоот хаягт байрлах орон сууц, эрхийн улсын бүртгэлийн Y-2203004506 дугаарт бүртгэлтэй, уг байрны 27 тоот хаягт байрлах орон сууцуудыг, эрхийн улсын бүртгэлийн Y-2203003515 дугаарт бүртгэлтэй уг байрны 02, 03 тоот үйлчилгээний зориулалттай эд хөрөнгөтэй нэгтгэх хүсэлт гаргасан байх тул эрхийн улсын бүртгэлийн Y-2203004044, Y-2203004506 дугааруудыг хүчингүй болгож, Y-2203003515 дугаартай бүртгэлд нэгтгэсүгэй.

2. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203004044, Y-2203004506 дугааруудтай бүртгэлүүдийг Y-2203003515 дугаартай бүртгэлд нэгтгэж байгаатай холбогдуулан эд хөрөнгө өмчлөх эрхийн 000120780, 0048067, 0025059 дугаартай гэрчилгээнүүдийг тус тус хүчингүй болгосугай.

3. Эрхийн улсын бүртгэлийн Y-2203004044, Y-2203004506 дугааруудтай хувийн хэрэг, бүртгэлд холбогдох бичилт хийж хаах, Y-2203003515 дугаартай бүртгэлд шинээр гэрчилгээ олгохыг Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Г.Өлзийбаярт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газрын дарга Г.Анхныбаяр, Сүхбаатар дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Ариунболд нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Р.СОДХҮҮ

006585



ОЮУНЫ ӨМЧ, УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/965

Улаанбаатар хот

Эрхийн улсын бүртгэлийн Y-2203021960
дугаарыг хүчингүй болгож, хувийн хэрэг,
бүртгэлийг хаах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

